

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 4/09

Арвайхээр сум

Аймгийн эрүүл мэндийн салбарын 2022-2025
стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 216 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн "Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай" 609 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Аймгийн эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2."Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын удирдлагын багт даалгасугай.

3.Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.


4.Тушаалын хэрэгжилтийг жил тутамд нэгтгэхийг Удирдлага төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа), хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийг газрын даргын 2023 оны 05
дугаар сарын 19-ны өдрийн 409р
тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2022-2025 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аймгийн эрүүл мэндийн салбар үндэсний болон салбарын хэмжээнд хэрэгжиж буй дараахь бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Монгол Улсын Их Хурлын 1999 оны 46 дугаар тогтоол "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоол "Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоол "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө (2006-2015): Монгол Улсын Их Хурлын 2007 оны 45 дугаар тогтоол "Монгол улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол " Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого Эрүүл мэндийн сайдын 2013 оны 176 дугаар тушаал "Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тоот тогтоол "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого". Түүнчлэн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хүн амын эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлаар нийт 44 үндэсний хөтөлбөр, стратегийг Засгийн газрын тогтоол (14) болон Эрүүл мэндийн сайдын тушаалаар (19), яамд хоорондын хамтарсан тушаалаар (1) 4-10 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж ирсэн. 2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу салбарт хэрэгжиж байсан дээрх олон төрлийн бодлогын баримт бичгийг хүчингүй болгон улсын хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, цагалбарыг баталгаажуулсан.

Өнөөгийн байдлаар салбарын хэмжээнд урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэл, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Дээрх хөгжлийн бодлогын баримт бичгийг амжилттай хэрэгжүүлэхэд салбарын хэмжээнд дунд хугацаанд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн төсөв, байгууллагын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6-д Төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүргийг заасан ба 9.6.5 дахь заалтад "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх" гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн Газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам болон төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны а/06 дугаар тушаал, салбарын стратеги боловсруулах өртгөтгөсөн ажлын хэсгийг 2023 оны а/03 дугаар тушаалаар байгуулан, нийт 7 удаагийн хэлэлцүүлгээр хэлэлцэн, эцэслэн боловсруулсан болно.

Үндэслэл, шаардлага

Аймгийн хүн амын тоо жил тутамд нэмэгдэж, сүүлийн 5 жилийн байдлаар 2000 аад иргэнээр нэмэгдсэн, цэвэр өсөлт мөн 2019 оноос тууштай нэмэгдэж байна. Хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг эрэмбэлэхдээ нэн тэргүүнд хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан руу чиглэх ёстой.


Сүүлийн 10 жилийн байдлаар халдварын бус өвчлөл, нас баралт тэргүүлж, тэр дундаа зүрхний ишеми өвчин, тархины цус харвалт нас баралтын шалтгааны эхэнд бичигдэж байна. Үүний зэрэгцээ элэг ходоодны хавдар, чихрийн шижин, осол, гэмтэл, зам тээврийн осол, амиа хорлолт, уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт тэргүүлж байна. Нийт нас баралтын 80-аад хувийг ХБӨ-ний шалтгаант нас баралт эзэлж байгаа нь эмнэл зүйн үйлчилгээний, зэрэгцээ урьдчилан сэргийлэх, бууруулах нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ чухал ач холбогдолтой. Осол гэмтлийг бууруулахад хөдөлмөрийн болон зам тээврийн аюулгүй байдлыг хангах дэд бүтцийн асуудал чухлаар тавигддаг. Амиа хорлохоос сэргийлэхэд зөвхөн эрүүл мэндийн салбар төдийгүй бусад салбарын оролцоо, хамтын ажиллагааг хангах сэтгэцийн эрүүл мэндийн бодлого шаардагдана. Иймд тэргүүлэх чиглэл болсон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жинхэнэ утгаар нь хөгжүүлснээр дараахь зорилтуудыг хангах юм.

НҮБ-ын 2030 хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод "ХБӨ-ний үүдэлтэй цаг бусын нас баралтыг 2025 он гэхэд 25 хувь, хөдөлгөөний хомсдолыг 10 хувиар бууруулахаар зорилт тависан. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Эрүүл Монгол хүн" хөдөлгөөний хүрээнд дэвшүүлсэн дараахь зорилтуудыг хангахыг зорино. Үүнд : Идэвхитэй хөдөлгөөнөөр хичээллэдэг хүн амын эзлэх хувь 17хувь байгааг 60 хувьд хүргэх, жимс, жимсгэний хэрэглээ 43, байгааг 50 хувьд хүргэх хүнс, ногооны хэрэглээ 30 хувь байгааг 50 хувьд хүргэх, давсны хэрэглээ 10,5 грамм байгааг 8,5 грамм болтол бууруулах, өөх тосны хэрэглээ 87,5 хувь байгааг 75 хувь хүртэл бууруулах хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдалт 32 хувь байгааг 80-аас дээш хувьд хүргэх зорилтуудыг хангаж ажиллана.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу салбарын чиг үүргийн мандатыг 2019 онд хийсэн. Уг шинжилгээгээр Монгол Улсын үндсэн хууль болон хүн амын эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдол бүхий нийт 231 хуульд дүн шинжилгээ хийсэн.

Дүн шинжилгээ хийхдээ эрүүл мэндийн салбарын чиг үүргийг дараахь байдлаар тодорхойлсон байна.



Чиг үүргийн дахин хуваарилах аргачлалын дагуу хийгдсэн дүн шинжилгээг үндэслэн салбарт мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчны хүрээнд мандатын шинжилгээг дараахь байдлаар хийв

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		231
Үүнээс	Тухай салбарын хэмжээнд шууд хамаарах хуулийн тоо	12
	Нийтлэг мөрдөж байгаа хуулийн тоо (бусад холбогдох хуулийн тоо)	219
Ерөнхий чиг үүрэг: Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүргийн оролцогчид
ҮЧҮ-1 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	1.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагаа	Аймаг, сум, багийн Засаг дарга нар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, боловсролын байгууллагууд, хүнс хөдөө аж ахуйн газар, байгаль орчин аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн даатгал, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, аж ахуйн нэгж байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэд,
	2.Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тандах үйл ажиллагаа	
	3.Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	
	4.Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл. сургалт. сурталчилгаа	
ҮЧҮ-2	5.Оношлох, эмчлэх тусламж, үйлчилгээ	

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	6.Сэргээн засах тусламж, үйлчилгээ	Аймаг, сумдын ЗДТГазар, төрийн өмчийн газар,төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эрүүл мэндийн даатгал, мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод
	7.Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны тусламж, үйлчилгээ	
	8.Яаралтай тусламж, үйлчилгээ	
ҮЧҮ-3 Эм зүйн тусламж, үйлчилгээ	9.Эмийн зохицуулалт, чанар, аюулгүй байдал	ЗДТГ-ын төрийн өмчийн газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон нутаг хариуцсан мэргэжилтэн, төрийн болон хувийн хэвшлийн бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага, эм ханган нийлүүлэх байгууллагууд, гадаад улсын эмийн үйлдвэрийн төлөөлөгчийн газар, мэргэжлийн холбоо, нийгэмлэг, төрийн бус байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл,
	10.Эм. эмнэлгийн хэрэгслийн хангамж үйлдвэрлэл, эрүүл мэндийн технологи	
	11. Эмийн зохистой хэрэглээ	
ҮЧҮ-4 Бусад үйл ажиллагаа	Хүний нөөцийн удирдлага Тусгай зөвшөөрөл Магадлан итгэмжлэл Эрүүл мэндийн даатгал	ЭМЯ, Эрүүл мэндийн өхгжлийн төв, Аймаг, сумдын ЗДТГазар, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эрүүл мэндийн даатгал, мэргэжлийн нийгэмлэг холбоод,

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх журмын нийт 69 захиргааны хэм хэмжээний акт (Сайдын тушаал) хэрэгжиж байгаагийн 36 нь бусад яамд (ХНХЯ. ХЗДХЯ. СЯ. БХБЯ, ХХААХҮЯ. БСШУЯ. БОАЖЯ) - тай хамтран баталсан 33, Эрүүл мэндийн сайд дангаар баталсан 36 тушаал байна.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн, эрүүл мэндийн чанар хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж, **аймгийн хүн амын дундаж наслалтыг 2025 онд 74-д хүргэнэ.**

ТАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тавьсан зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлыг төлөвлөлтийн баримт бичигт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх зорилгоор салбарын өнөөгийн нөхцөл байдалд дотоод, гадаад орчны давуу болон сул талыг тодорхойлсон ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ хийв.

Нэг. ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
1.Бүтэц, зохион байгуулалт	

<ul style="list-style-type: none"> - Сум бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүтэц, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоотой - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг баталгаажуулсан стандарттай - Тусламж үйлчилгээг зэргэлдээх аймгуудад үзүүлэх Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй. - Тусламж үйлчилгээг анхан болон лавлагаа шатлалын хэлбэрээр үзүүлэх тогтолцоо бүрэлдсэн. - БОЭТ болон Хархорин сумын НЭ-ийн дэргэд Эрүүл мэндийг дэмжих төв байгуулагдсан - Хүн ам олонтой Уянга сумын Жаргалант баг, Нарийнтээл сумын Баянтээг багт ор бүхий багийн эрүүл мэндийн төвтэй - Ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тоо нэмэгдэж, магадлан итгэмжлэгдэн үйл ажиллагаа жигдэрсэн 	<ul style="list-style-type: none"> - Зарим сумд аймгийн төвөөс хэт ойр зарим нь алслагдсан байдалтай оршдог - Стандарт нь сумын эрүүл мэндийн төвд бүрэн хэрэгжих боломж хязгаарлагдмал - БОЭТ-д харьяа бусад аймгаас ирж үйлчлүүлж байгаа иргэдийн тоо маш бага - Эмнэлгүүдийн шударга өрсөлдөөн нэмэгдэхийн зэрэгцээ зарим эмнэлэгт дампуурал бий болох эрсдэлтэй
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Хүн амын дундаж наслалт улсын дундажаас өндөр (72.8) - Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгээр улсад тэргүүлдэг - Тоног төхөрөмжийн хангалт стандартын үзүүлэлтээр 88 хувьтай - 	<ul style="list-style-type: none"> - Эрэгтэй, эмэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтын шалтгаантай холбоотой дундаж наслалт зөрөө (4,5) - Нас баралтын тэргүүлэх шалтгаан болох зүрх судасны эмгэг сүүлийн 10 жилд 1,6 пунктээр л буурсан. - Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшнээр улсын дундажаас өндөр - Нийт хавдрын нас баралтын 40,7 хувийг элэгний хорт хавдар эзэлж байна - Тав хүртэлх насны хүүхэд, нялхас, нярайн эндэгдлийн түвшин улсын дундажаас өндөр - Сүүлийн 4 жилд жил бүр эхийн эндэгдэл бүртгэгдсэн - Эхээс урагт дамжих халдварын илрүүлэлт хангалтгүй -
2. Хүний нөөц	

<ul style="list-style-type: none"> - Салбарын хүний нөөц бэлтгэх тогтолцоо бүрэлдсэн - Эрүүл мэндийн ажилтны ажил мэргэшлийн индекс баталгаажсан - Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг баталгаажуулсан - Эрүүл мэндийн ажилтанг анхан шат болон орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилго бүхий тэтгэвэр тэтгэмжийн асуудлаарх эрх зүйн орчин хуулиар баталгаажсан 	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэн гаргаж байгаа сургуулиудын чанар жигд бус - Их эмчийн тоо хангалттай хэдий ч хөдөө орон нутагт их эмч дутагдалтай - Зарим төрлийн нарийн мэргэшлийн эмч дутагдалтай цөөн бэлтгэгдсэн (дүрс оношилгоо, эмгэг судлаач) - Их эмчтэй харьцуулахад сувилагчийн тоо цөөн, (1:1,4) нарийн мэргэшсэн сувилагч нар хангалттай бус (Сэргээн засах, хүүхэд, яаралтай тусламж, дархлаажуулалтын сувилагч) - Орон нутагт ажиллах эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай - Орон нутагт ажиллах эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгаа (байр орон сууц) бүрэн хангагдаагүй - Эмч нарыг нарийн мэргэшүүлэх үйл явц тусламж үйчилгээний хэрэгцээ шаардлагатай уялдах уялдаа сул - 10000 хүн амд ногдох их эмч, сувилагчийн тоогоор улсын дундажаас бага
3.Салбарын санхүүжилт	
<ul style="list-style-type: none"> - Салбарын санхүүжилтийн шинэчлэл эхэлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрч эхэлсэн - Эрүүл мэндийн даатгалын сан ЭМЯ-ны харьяанд шилжин ирсэнтэй холбогдуулан салбарын санхүүжилт нэмэгдсэн - Анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт 2015 оноос хойш 4 дахин нэмэгдэхийн зэрэгцээ зарим төрлийн тусламж үйлчилгээг ЭМД-ын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн - Алслагдсан орон нутагт тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад алслагдсан орон нутгийн индекс ашиглаж эхэлсэн - ЭМД-с санхүүжиж байсан тусламж үйлчилгээний нэр төрөл, санхүүжилтийн хувь нэмэгдэж байгаа 	<ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэлийн санхүүжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, хүний нөөцийн мэдлэг чадвар дутмаг, ойлголт хандлага жигд бус - Эрүүл мэндийн салбарын санхүүжилт ДЭМБ-аас улс орнуудад зөвлөмж болгосон хэмжээнд хүрэхгүй байгаа - Хувь хүний төлөх төлбөрийн хэмжээг орон нутагт тооцож судлаагүй - Салбарын санхүүгийн нөхцөл байдлыг илтгэх Үндэсний тооцооны чадавх бүрэн бүрэлдээгүй - Эрүүл мэндийн эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц салбарын хэмжээнд хэт цөөн
4.Мэдээлэл технологи	
<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн нэг хэсэг нь Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт болж байгаа - ЭМБ-ууд бүгд интернет ашиглах боломжоор хангагдсан - ЭМБ-ууд цахимаар мэдээлэл, тайлан гаргах программ хангамжтай 	<ul style="list-style-type: none"> - Салбарт хэрэглэгдэж байгаа программ хангамжууд хоорондоо хөрвөх боломжгүй нэгдмэл бус, мэдээлэл солилцооны нэгдсэн платформ байхгүй - Програмын хөгжүүлэлт хийх үйл ажиллагаа хувь хүн, компаниас хараат

<ul style="list-style-type: none"> - ЭМБ-дад мэдээлэл технологийн ажилтан ажиллуулах эрх зүйн орчин бүрдсэн 	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн технологийн чиглэлээр хүний нөөц дутмаг - Эрүүл мэндийн ажилтнуудын мэдээллийн технологийн талаарх чадавх сул - Байгууллагуудын компьютер түүний дагалдах хэрэгслийн хүчин чадал хангалтгүй, хуучирсан - Мэдээллийн технологийн ажилтны цалин хөлс бага - Зарим эмч, мэргэжилтнүүд цахимд ажиллах туршлага, ур чадвар бага, гэнэт сүлжээ тасрах үед үүсэх эрдсэл тусламж үйлчилгээнд нөлөөлөх
5.Салбарын засаглал, ил тод байдал	
<ul style="list-style-type: none"> - Салбарын хэмжээнд эмнэлгийн хагас бие даасан байдал хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн - Эрүүл мэндийн байгууллагуудад Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн - Салбарын хэмжээнд болон орон нутаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг түвшин бүртээ вебсайт хуудсаар дамжуулан хүргэж байна. - Салбарын хэмжээнд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөвлөл байгуулагдан ажиллаж байна - Салбарын хэмжээнд зарим үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлдэг 	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн чадавх дутмаг - Салбарын хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг бодитой үнэлэх тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, хөндлөнгийн хяналтын механизм сул - Эмч, эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага хангалтгүй - Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, цогц арга хэмжээний хэрэгжилт, түүний хэрэгжилтийн үнэлгээ олон нийтэд ил тод бус
Хоёр.ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
1. УИХ, Засгийн газрын түвшинд	
<ul style="list-style-type: none"> - Улсын хэмжээнд урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлсон бодлогын баримт бичиг батлагдан улс орон даяар хэрэгжиж эхэлсэн - Корона вируст халдвар /КОВИД-19/ цартахлын нөхцөл байдал, сургамжит байдалд үндэслэн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэмжлэг нэмэгдэж байгаа 	<ul style="list-style-type: none"> - Дэлхийн болон улс орны эдийн засгийн хямралтай холбоотойгоор бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй болох, эрүүл мэндийн салбарын санхүүжилт хөрөнгө оруулалтын хэмжээ буурах
2. Хууль эрх зүйн зохицуулалтын хувьд	
<ul style="list-style-type: none"> - Хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах чиглэлээрх хууль эрх зүйн орчин хангалттай бүрэлдсэн 	<ul style="list-style-type: none"> - Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа гол гол хуулиудад ойр ойрхон хугацаанд нэмэлт өөрчлөлт байнга орж байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. - Хуулийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, тогтмол хянах хүний нөөц, чадавх хангалттай бус байгаагаас хууль тогтоомжийн хэрэгжилт сул байна.

3. Улс орны нийгэм, эдийн засгийн үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Дэлхийн тэргүүлэх 2 эдийн засаг (зах зээл)-т ойр байрлал, хоёр хөрштэй найрсаг хамтын ажиллагаа, зах зээл, эдийн засгийн ирээдүйн боломж; - Мэдээлэл технологийн эрчимжилт, цахим шилжилт - Байгалийн цэвэр, органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж экспортлох боломж; - Аймаг орон нутгаас жил бүрийг тухай үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилтот жил болгон хэрэгжүүлдэг - Арвайхээр суманд дулааны цахилгаан станц баригдаж ашиглах нь хүн амын эрүүл мэндэд джмулжт орчин бүрдэнэ. 	<ul style="list-style-type: none"> - Засаглал сул, бодлого тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтын орчныг муутгаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхэх аюултай; - Гадаад өрийн дарамт өндөр; - Уул уурхайгаас хэт хамаарал бүхий эдийн засгийн бүтэцтэй, Экспорт, импортын хувьд ганц зах зээлээс хараат байдал өндөр; - Олон их дээд сургуультай боловч боловсролын чанар муу; - Хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн хөрс, утаа орчны бохирдол их; - Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар нэмэгдэж байгаа; - Хүн амын өвчлөл, нас барагтын тэргүүлэх шалтгаан нь ихэвчлэн амьдралын хэв маягаас үүдэлтэй харьцангуй сэргийлж болох нас баралт эзэлж нэмэгдэх хандлагатай; - Кибер аюул заналд өртөх, мэдээллийн аюулгүй байдал сул.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

ОЛОН УЛСЫН ЖИШИГ- ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ӨВӨРХАНГАЙ-Д

Зорилтууд:


- ✓ Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ.
- ✓ Иргэд жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамрагддаг, эрүүл амьдралын хэв маягтай болох соёлыг хэвшүүлнэ.
- ✓ Эрүүл мэндийн урт хугацааны тусламж үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламжийг хөгжүүлнэ.
- ✓ Аймгийн хэмжээний яаралтай түргэн тусламжийн тогтолцоог боловсронгуй болгоно
- ✓ Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулна.
- ✓ Орчин үеийн дэвшилтэт оношилгоо, эмчилгээ, сувилгааны технологийг нутагшуулна.
- ✓ Эмийн чанар, аюулгүй байдлын цахим тогтолцоог бүрдүүлж, клиникийн эм зүйг хөгжүүлнэ.
- ✓ Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээг хиймэл оюун ухаан, алсын зайн болон мобайл технологи, цахим үйлчилгээнд тулгуурлан хөгжүүлнэ.
- ✓ Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлэх замаар байгууллагын болоод мэргэжилтний хөгжил, нийгмийн асуудлыг дэмжинэ.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА ЗУРАГЛАЛ

2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд ЭМГ, БОЭТ, ЗӨСТ, Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв 17, өрхийн эрүүл мэндийн төв 4, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 7, үүдэн клиникийн эмнэлэг 28, рашаан сувилал 7, эм ханган нийлүүлэх байгууллага 5, эмийн сан 54, бусад 3, нийт 141 эрүүл


мэндийн байгууллагад нийт 1685 эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаа бөгөөд үүнээс 305 их эмч, эх баригч 54, багийн бага эмч 54, сувилагч 396, эмнэлгийн мэргэжилтэн 328 ажиллаж байгаа бөгөөд эмч, сувилагчийн харьцаа аймгийн түвшинд 1:1,4 байна.

Мэргэжлийн ахлах болон тэргүүлэх зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 21,7 хувь, боловсролын магистр зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 4,6 хувийг эзэлж байна. Улсын төсвийн санхүүжилт, орон нутгийн зардлаар үндсэн, болон төрөлжсөн нарийн мэргэшил эзэмшсэн, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан их эмч нар 74,4 хувь, сувилагч, бусад мэргэжилтэн 56,5 хувийг эзэлж байна.



НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН

Аймгийн хүн амын дундаж наслалтыг 2025 он гэхэд 74-т хүргэнэ.



Д/д	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин (аймгийн дундаж түвшингээс тооцов)			Хүрэх түвшин 2025
			Суурь түвшин	2023	2024	
Хүн ам зүйн үзүүлэлтүүд						
1	Хүн амын дундаж няслалт	Жил	72,8	73,1	73,5	74,0
2	Төрөлтийн нийлбэр коэффициент / нэг эмэгтэйд ноогдох төрөлт/	Тоо	2,1	2,5	2,9	3,3
Чиг үүрэг 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр						
1	Халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тандалт	-Бүртгэгдсэн өвчлөлийн түвшин (10000 хүн амд) -Нас баралтын түвшин(10000 хүн амд)	453 0	400- аас доош	370 аас доош	350-аас доош
2	Нийт урьдчилан сэргийлэх болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалт	-Артерийн даралт ихсэлтийн эрт илрүүлгийн (18-аас дээш нас)хувь -чихрийн шижингийн эрт илрүүлгийн (40-аас дээш нас)хувь -хөхний өмөнгийн эрт илрүүлгийн (40 түүнээс дээш нас)хувь -умайн хүзүүний эрт илрүүлгийн (30 ба түүнээс дээш) -Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь Цусан дахь өөх тосны хэмжээг хянах /40-аас дээш насанд/	41,3 64,7 78,0 58,0 35,4 32,0	82,5 69,7 82,0 63,0 40,0 40,0	94,5 80,0 85,0 70,0 45,0 50,0	100,0 90,0 90,0 90,0 50,0 60,0 60,0
3	Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо	Нийт хүн амын хамрагдалтын хувь Хорт хаврын 7 эрт илрүүлгийн хувь	28,8 42,8	50,0 70,0	60,0 80,0	90,0 90,0
4	Хүн амын дунд тэргүүлж буй халдварт бус өвчлөл, нас баралт(10000 хүн амд)	-Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин -Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин -Амиа хорлох нас барсан тохиолдлын түвшин -Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин	21,6 12,4 0,9 1,0	18,0 12,3 0,7 0,7	16,8 11,5 0,5 0,6	15,4 10,5 0,3 0,4

		- Зам тээврийн ослын шалтгаант Нас баралтын түвшин	1,9	1,85	1,83	1,80
5	Халдварт өвчлөл, нас баралт	-В вирус гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь -Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, Вегепатит, хемофлюсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь 3-р тун -Улаан буурхан гахайн хавдар, улаануудын эсрэгсэргийлэх тарилгын хамралтын хувь 2-р тун - Сүрьеэгийн өвчлөгийн түвшин(10000 хүн амд) - Вирус гепатитын өвчлөгийн түвшин(10000 хүн амд)	99,0 94,9	99,0 аас дээш 94,9 – аас доошгүй	99,0 аас дээш 94,9 – аас доошгүй	99,0 аас дээш 94,9 – аас доошгүй
		6 настнуудын Зүрх судасны тогтолцооны үзлэгт хамрагдалтын хувь	-	50,0	90,0	100,0
6	Эрүүл мэндийн хяналт, тандалт	9 настнуудын Амьсгалын эрхтнүүдийн тогтолцооны үзлэгт хамрагдалтын хувь 12 настнуудын Хоол боловсруулах тогтолцооны үзлэгт хамтрагдалтын хувь 15 настнуудын Шээс бэлгийн тогтолцооны үзлэгт хамрагдалтын хувь Оюутны үзлэгт хамрагдалтын хувь	- - - -	50,0 50,0 50,0 80,0	90,0 90,0 90,0 90,0	100,0 100,0 100,0 100,0
7		Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг утасны тоо	-	4	8	12
8	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ	Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг нэгжийн тоо	-	4	8	10
9		Амиа хорлолтын түвшин	0,94	0,93	0,92	0,90
10		Сэтгэл зүйчтэй сургуулийн тоо	8	10	12	15
11		Хогоо ялгах сургалтад хамруулсан айл өрхийн тоо	-	500	1000	2000
12	Орчны эрүүл мэнд	Эмнэлгийн хог хаягдал, устгалын стандартын хэрэгжилт	40,0	60,0	70,0	80,0
13		Агаарын бохирдлын үзүүлэлт: Азотын давхар исэл	33	бууруулах		

		Хүхэрлэг хий Тоосонцор	36 59		Жил тутам бууруулах	Жил тутам бууруулах
14		Усны бохирдлын үзүүлэлт/Нян илэрсэн ундны устай газрын тоо	7 сум	бууруулах	Жил тутам бууруулах	Жил тутам бууруулах
15		Хөрсний бохирдлын үзүүлэлт/Нүхэн жорлонтой айл өрхийн эзлэх хувь	78,2 хувь	бууруулах	Жил тутам бууруулах	Жил тутам бууруулах
Чиг үүрэг 2: Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр						
16	Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор явууллын (Мобайл) эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Явууллын (Мобайл) эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	-	Нийт хөдөөгийн хүн амын 20- оос доошгүй хувь	Нийт хөдөөгийн хүн амын 40- оос доошгүй хувь	Нийт хөдөөгийн хүн амын 60- оос доошгүй хувь
17	Сумын эрүүл мэндийн төвүүдийн барилгын цэвэр, бохирын шугам	Шийдвэрлэлтийн хувь	70,0	80,0	90,0	100,0
18	Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулан, гурвалсан халдварын шинжилгээнд хамрагдалт	-Эхийн эндэгдлийн түвшин(100000 амьд төрөлт тутамд) - Нарайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) -Жирэмсний эрт үеийн хяналтын хувь --Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд) -Гурвалсан халдварын шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	50,3 9,1 93,5 6,0 95,0	00 7,5 96,5 5,5 100,0	00 7,2 97,0 5,0 100,0	00 6,9 98,0 4,5 100,0
19	Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) -5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) -0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10000 хүүхдэд -Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин -18, 36 сар, 6 нас, тай хүүхдүүдийн эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэг хийсэн хувь	12,6 16,6 21,5 10,4 0	12,3 13,2 20,5 9,4 50- аас дээш хувь	10,3 12,5 19,0 8,8 80,0	10,0 11,7 18,0 8,0 90,0

Чиг үүрэг 3: Эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр						
20	Антибиотекийг эмийн жороор хэрэглэх хэрэглээний түвшин	Антибиотекийг эмийн жороор хэрэглэх хувь	40,0	50,0	60,0	70,0
21	Эмийн жор бичиглтийн стандартын хэрэгжилт	Эмийн жор бичиглтийн стандартын хувь	50,0	60,0	70,0	80,0
22	Клиникийн эм зүйчтэй болсон байгууллага	Клиникийн эм зүйчтэй байгууллагын тоо	1	2	4	6
23	Эмч нарын эмийн зохистой хэрэглээний сургалтад хамрагдалт	Эмч нарын эмийн зохистой хэрэглээний сургалтад хамрагдсан хувь	50,0	70,0	80,0	100,0
24	Эмийн сангуудын стандартын хэрэгжилт	Эмийн сангуудын стандартын хэрэгжилтийн хувь	65,0	75,0	85,0	95,0
25	Иргэдийн эмийн зохистой хэрэглээний хандлага, дадал	Иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлагын хувь	40,0	50,0	60,0	70,0
Чиг үүрэг 4: Бусад чиг үүрэг						
26	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны салбарын болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь Нарийн мэргэзлэлийн их эмчийн тоо	94,0 255	95,0 265	97,0 275	100,0 285
27	Хүний нөөцийг бүрдүүлэх 3-5 жилийн төлөвлөлттэй ажиллах	Эмч, сувилалчийн харьцаа Хэрэгжилтийн хувь	1:1,4 84,0	1:1,5 88,0	1:1,7 90,0	1:2 100,0
28	Сувилалч мэргэжлээр тайлангийн жилд орон нутгаас зардлыг даан сургасан шинэ сувилалчийн тоо	Сургалтад хамруулсан шинэ сувилалчийн тоо	6	10	15	19
29	Хүний нөөцийн нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Төгрөгөөр	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр
30	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтэц	-Техник хэрэгслээр хангасан тоо -Интернетийн хурдыг нэмэгдүүлсэн үзүүлэлт	- 14МВ	Гүйцэтгэлээр 20МВ	Гүйцэтгэлээр 25 МВ	Гүйцэтгэлээр 30 МВ -аас дээш
